

2026 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 47

Улаанбаатар хот

“Дотоод аудитын бодлого”-ыг шинэчлэн батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13, 76.1.18 дахь заалт, Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.7, 33.6 дахь заалт, “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.11.21 дэх заалтыг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Худалдаа, хөгжлийн банкны “Дотоод аудитын бодлого”-ыг энэхүү тогтоолын Хавсралт 1-ийн дагуу шинэчлэн баталсугай.
2. Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 5 дугаар сарын 12-ны 52 тоот тогтоолын Хавсралт 2-ыг хүчингүй болгосугай.
3. Энэхүү тогтоолыг 2026 оны 6 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Дотоод аудитын газар (Ч.Лхагвасүрэн)-т, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо (Ж.Болормаа)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



РАНДОЛФ КОППА



 Дотоод аудитын газар

Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирлах зөвлөлийн 2026 оны 06 сарын 25 ны өдрийн 47 тоот тогтоолын Хавсралт 1

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНКНЫ ДОТООД АУДИТЫН БОДЛОГО

(Шинэчилсэн найруулга)

ТОВЧИЛСОН ҮГ

The ИА	The ИА (The Institute of International Auditors)- Дотоод аудиторуудын институт.
ОУМПХ (IPPF)	Олон улсын мэргэжлийн практикийн хүрээ (The International Professional Practices Framework). Дотоод аудиторуудын институтээс баталсан дотоод аудитын мэргэжлийн удирдамж бүхий баримт бичиг.
ДАДС	Дотоод аудитын дэлхийн стандарт. ОУМПХ-ний заавал дагаж мөрдөх бүрэлдэхүүн хэсэг бөгөөд дотоод аудитын мэргэжлийн дэлхийн практикийг хөтлөн чиглүүлэх, дотоод аудитын үйл ажиллагааны чанарыг үнэлэх, сайжруулахад зориулагдсан, дотоод аудиторуудад дотоод аудитын зорилгыг биелүүлэхэд туслах баримт бичиг.
Банк	Худалдаа, хөгжлийн банк
ТУЗ	Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл
ДАГ	Худалдаа, хөгжлийн банкны Дотоод аудитын газар

ГАРЧИГ

НЭГ.	НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ
ХОЁР.	ДОТООД АУДИТЫН ЗОРИЛГО
ГУРАВ.	ДОТООД АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ
ДӨРӨВ.	ДОТООД АУДИТЫН МЭРГЭЖЛИЙН ШААРДЛАГА
ТАВ.	ДОТООД АУДИТЫН ЭРХ
ЗУРГАА.	ДОТООД АУДИТЫН ҮҮРЭГ
ДОЛОО.	ДОТООД АУДИТЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА
НАЙМ.	ДОТООД АУДИТЫН ТАЙЛАГНАЛТ
ЕС.	ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ХҮНИЙН НӨӨЦИЙН БОДЛОГО
АРАВ.	ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ЧАНАР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Худалдаа, хөгжлийн банкны Дотоод аудитын бодлого (цаашид “Бодлого” гэх)-ын зорилго нь Худалдаа хөгжлийн банкны эрхэм зорилго, банкны урт хугацааны стратегийн зорилгуудыг чиглэл болгон хууль тогтоомж, олон улсын стандартын шаардлагын дагуу дотоод аудитын үйл ажиллагааны зорилго, хамрах хүрээ, мэргэжлийн шаардлага, дотоод аудитын үйл ажиллагааг гүйцэтгэх субъект, түүний эрх, үүрэг, хамтын ажиллагаа болон тайлагнах харилцааг тодорхойлоход оршино.
- 1.2. Банкны Дотоод аудитын бодлого нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Банкны дүрэм, бодлого, журам, заавар болон дотоод аудитын Олон улсын мэргэжлийн практикийн хүрээтэй нийцсэн байна.
- 1.3. Дотоод аудитын газар (цаашид “ДАГ” гэх) нь Дотоод аудитын бодлогыг хэрэгжүүлэхдээ зарчимд суурилан ажиллах бөгөөд болж өнгөрсөн үйл ажиллагааг шалгаж дүгнэлт өгөхөөс гадна ирээдүйд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, үйл ажиллагааны үр өгөөж болон бүтээмжийг нэмэгдүүлэх, алсыг харсан сайжруулалтад чиглэх бодлогыг баримтална.
- 1.4. ДАГ нь аудит хийх үйл ажиллагаанд хамаарах эрсдэлийг тодорхойлохдоо залилантай холбоотой эрсдэлүүдийг харгалзан үзэх бөгөөд хэрэв тухайн аудитаар залилан, залилангийн шинжтэй үйлдэл, нөхцөл байдал илэрвэл залилангийн аудитыг хийж гүйцэтгэнэ. Залилангийн аудитыг гүйцэтгэхдээ энэхүү бодлогыг баримтлан, “Дотоод аудитын газрын журам”-ын дагуу ажиллана.
- 1.5. Дотоод аудитын газрын удирдлага (цаашид “Аудитын гүйцэтгэх удирдлага” гэх) нь Дотоод аудитын бодлогыг жил бүр эргэн харж шаардлагатай өөрчлөлт, шинэчлэлтийг хийх, Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-өөр батлуулах болон хэрэгжилтэд анхаарч ажиллана.
- 1.6. Дотоод аудитын үйл ажиллагааны нарийвчилсан зохицуулалтыг “Дотоод аудитын газрын журам”-аар, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны үйл ажиллагааг “Аудитын хорооны дүрэм”-ээр тус тус зохицуулна.

ХОЁР. ДОТООД АУДИТЫН ЗОРИЛГО

- 2.1. Дотоод аудит нь байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх, хамгаалах, дэмжих, чадварыг бэхжүүлэхийн тулд ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагад хараат бус, эрсдэлд суурилсан, бодитой баталгаажуулалт болон зөвлөх үйлчилгээ үзүүлэх, гүн ойлголт, алсыг харсан зөвлөгөө өгөх үйл ажиллагаа юм. Дотоод аудит нь байгууллагыг зорилгодоо амжилттай хүрэхэд нь дэмжиж, байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, хяналтын үйл явц, шийдвэр гаргалт ба түүнд тавих хяналт, оролцогч талуудын итгэл, нэр хүнд, олон нийтийн ашиг сонирхолд үйлчлэх чадварыг сайжруулдаг. Дотоод аудит нь дараах 2 төрөлтэй байна:
 - 2.1.1. **Баталгаажуулалт** нь байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, хяналтын үйл явцуудын талаарх оролцогч талуудын¹ итгэлийг нэмэгдүүлэх зорилготой дүгнэлт гаргахад чиглэн, шалгаж буй асуудал, нөхцөл байдал, сэдэв, үйл ажиллагааг тогтоосон шалгууртай харьцуулан бодитой үнэлэх ажиллагаа юм.

¹ Оролцогч талууд - Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнтэй шууд болон шууд бус сонирхлоор холбогддог талууд (үүнд, ТУЗ, гүйцэтгэх удирдлага, ажилтнууд, харилцагчид, нийлүүлэгчид, хувьцаа эзэмшигчид, зохицуулагч байгууллага, хөндлөнгийн аудитор болон холбогдох бусад этгээдүүд)

- 2.1.2. **Зөвлөх үйлчилгээ** нь бодлогын 2.1.1 заалтад тодорхойлсон баталгаажуулалтын дүгнэлт, мэдэгдэл гаргахгүй бөгөөд удирдлагын үүрэг хариуцлага хүлээхгүйгээр байгууллагын дотоод оролцогч талуудад зөвлөгөө өгөх үйлчилгээ юм. Зөвлөх үйлчилгээний мөн чанар, хамрах хүрээг үйлчилгээг хүлээн авах талуудтай зөвшилцсөний үндсэнд тогтооно. Зөвлөх үйлчилгээг ДАГ-ын санаачлагаар эсвэл ТҮЗ, Аудитын хороо, гүйцэтгэх удирдлага, эсвэл бусад удирдлагын хүсэлтээр хийж болно.
- 2.2. Дотоод аудитын үйл ажиллагаа нь Банкны оролцогч талуудын эрх ашгийн төлөө байх бөгөөд дараах үнэ цэнийг бий болгох зорилготой байна:
- 2.2.1. **Банкны үйл ажиллагааны хэвийн болон тасралтгүй сайжирч буй байдал**
Байгууллагын Засаглал, Эрсдэл, Хяналтын үр дүнтэй байдалд бодитой баталгаажуулалт хийж, үйл ажиллагааг нь хэвийн байлгахад чиглэн ажиллахаас гадна цаашид анхаарах, эрсдэлтэй асуудлыг тодорхойлон банкны стратеги, үйл ажиллагаа, санхүү, нийцлийг сайжруулах зөвлөмжийг өгөх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлнэ;
- 2.2.2. **Банкны зорилгодоо хүрэх байдал**
Гадаад, дотоодын эх сурвалжийг ашиглан бизнесийн үйл явцад дүн шинжилгээ хийж, алсыг харсан санал, санаачилга дэвшүүлэх замаар стратегийн зорилго, зорилтдоо хүрэхэд нь дэмжинэ;
- 2.2.3. **Оролцогч талуудын Банканд итгэх итгэл**
Дотоод аудитын үйл ажиллагааг хараат бус, хариуцлагатай, шударгаар гүйцэтгэж, бодитой үнэлэлт, дүгнэлт өгөх замаар тус үнэ цэнийг бий болгоно.
- 2.3. Дотоод аудитын дүгнэлт нь Банкны үйл ажиллагаанд үнэ цэн нэмэхүйц, цаг үеийн шаардлагад нийцсэн, байгууллагын цаашдын үйл ажиллагаанд эерэг нөлөө авчрах, эрсдэлээс урьдчилан сэргийлсэн, алсыг харсан, бодитой байх бөгөөд аливаа нөлөөллөөс ангид байна.

ГУРАВ. ДОТООД АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ

- 3.1. Банкны дотоод аудитын үйл ажиллагаа нь дараах **үндсэн чиглэлүүдийг** хамарна:
- 3.1.1. Байгууллагын Засаглал, Эрсдэлийн удирдлага, Дотоод хяналтын үйл явцын үр дүнтэй байдлыг үнэлэх;
- 3.1.2. Хууль тогтоомж, дүрэм, бодлого, төлөвлөгөө, журам, зааврын нийцлийг хянаж, үнэлэх (үүнд мөнгө угаах болон терроризмтэй тэмцэх үйл ажиллагаатай холбоотой олон улсын хууль, дүрэм мөн хамаарна);
- 3.1.3. Мэдээллийн найдвартай байдлыг үнэлэх;
- 3.1.4. Банкны хөрөнгийг хамгаалах;
- 3.1.5. Банкны үйл ажиллагаанд нөлөө үзүүлэхүйц аливаа өөрчлөлтийг үнэлэх.
- 3.2. Дотоод аудитын **баталгаажуулалт** нь дараах чиглэлээр хийгдэнэ:
- 3.2.1. Банкны стратегийн зорилтуудыг биелүүлэхэд учирч болзошгүй гол эрсдэлүүдийг зохих ёсоор тодорхойлж, эрсдэлийг удирдаж буй байдал;

- 3.2.2. Төлөвлөгөө, тавьсан зорилтууд биелсэн эсэх; төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн нь тодорхойлсон зорилго, зорилтдоо хүрсэн байдал;
- 3.2.3 Санхүүгийн удирдлага, санхүүгийн бүртгэл, тайлагналт нь үнэн зөв, найдвартай, цаг хугацаандаа хийгдэж буй байдал;
- 3.2.4 Нөөцийг² хэмнэлттэй буюу үр ашигтайгаар хуваарилж, зарцуулалт нь үр ашигтай байж, ижил түвшинд хамгаалагдаж чадаж буй байдал;
- 3.2.5 Мэдээллийг тодорхойлох, хэмжих, шинжлэх, ангилах, тайлагнахад ашигласан арга хэрэгсэл нь найдвартай, үнэн зөв эсэх;
- 3.2.6 Банк залилангийн эрсдэлээ зохистой бөгөөд үр дүнтэй удирдаж буй байдлыг үнэлж, дүгнэх.
- 3.2.7 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх банкны үйл ажиллагаа, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод бодлого, журам, хяналтын хөтөлбөрийн хэрэгжилт, үр нөлөөг үнэлж, дүгнэх.
- 3.3 Дотоод аудитын **зөвлөх үйлчилгээ** нь дараах чиглэлээр хийгдэнэ:
 - 3.3.1 Шинэ бодлого, үйл явц, систем болон бүтээгдэхүүн үйлчилгээний загвар боловсруулах, хэрэгжүүлэхэд зөвлөгөө өгөх, залилан, санхүүгийн зөрчилтэй холбоотой форенсик шинжилгээний үйлчилгээ үзүүлэх, эрсдэл ба хяналтын талаарх хэлэлцүүлэг өрнүүлэх, сургалт хийх гэх мэт.

ДӨРӨВ. ДОТООД АУДИТЫН МЭРГЭЖЛИЙН ШААРДЛАГА

Хараат бус байдлыг хангах

- 4.1 Дотоод аудитууд хариуцсан ажлаа гүйцэтгэх явцдаа аудитын сэдэв, төрөл, хамрах цар хүрээ, түүвэр, аргачлал, давтамж, хугацаа болон тайлангийн агуулга зэрэгт аливаа нөлөөлөл, сонирхлын зөрчлөөс ангид байж, хараат бус байдлаар ажиллана.
- 4.2 Аудиторуудад дотоод аудит хийх ерөнхий эрхийг Аудитын хорооноос, тухайн үйл ажиллагаанд аудит хийх эрхийг Аудитын гүйцэтгэх удирдлагаас тус тус олгоно.
- 4.3 Аудитын гүйцэтгэх удирдлага нь дотоод аудиторын хараат бус байдал алдагдсан гэж үзвэл энэ талаар тодруулга бичиж Аудитын хороонд, шаардлагатай бол ТУЗ-д мэдэгдэнэ.
- 4.4 Дотоод аудитууд нь аудитын ажлыг бодитой гүйцэтгэх, өөрийн хийж буй ажилдаа итгэл үнэмшилтэй байх, аудитын бодит үр дүнг өөрчлөх аливаа тохиролцоог хийхгүй, бусдын үзэл бодолд автахгүй байх хэмжээний хандлага, сэтгэл санааны бэлтгэлтэй байна.
- 4.5 Дотоод аудитууд нь хараат бус байдалд нөлөөлөхүйц дараах ажил үүргийг гүйцэтгэхгүй:
 - 4.5.1. Банкны газар, хэлтэс, нэгжийн үйл ажиллагаанд аливаа хэлбэрээр оролцох, өмнөөс нь үүрэг хүлээх;

²**Нөөц** гэдэгт үйл ажиллагаанд идэвхтэй ашиглагдах аливаа төрлийн хөрөнгүүдийг, тухайлбал, тоног төхөөрөмж, програм хангамж, эд хөрөнгө, санхүүгийн болон хүний нөөц зэргийг ойлгоно.

- 4.5.2. Гүйцэтгэх удирдлагаас хэрэгжүүлж буй аливаа төсөл, хөтөлбөр, ажлын хэсэгт зөвлөхөөс бусад байдлаар оролцох, өмнөөс нь үүрэг хүлээх;
 - 4.5.3. Санхүүгийн болон санхүүгийн бус гүйлгээ хийх;
 - 4.5.4. Гүйцэтгэх удирдлагын хариуцсан үйл ажиллагааны бодлого, заавар, журмыг боловсруулах, шинэчлэх;
 - 4.5.5. Систем суурилуулахад оролцох, туршилт хийх;
 - 4.5.6. Гүйцэтгэх удирдлагын өмнөөс эрсдэлийн удирдлага, дотоод хяналтыг хэрэгжүүлэх.
- 4.6 Банкны дотоод аудитын үйл ажиллагаанд албан ёсоор томилогдсон³ эсвэл нэмэлт хүч⁴ байдлаар ажиллахаас бусад тохиолдолд ДАГ нь ажил олгогч болохгүй. Аудитын ажилд түр томилгоо хийх, нэмэлт нөөц авах асуудлыг Аудитын хорооны шийдвэрээр хэрэгжүүлнэ.
- 4.7 Дотоод аудиторын өмнө нь гүйцэтгэж байсан ажил болон дараа нь гүйцэтгэх ажилтай холбоотой хараат бус байдал алдагдах эрсдэлийг Аудитын гүйцэтгэх удирдлага хариуцаж ажиллах ба дараах зарчмыг баримтална:
- 4.7.1. Аудитор нь гүйцэтгэж байсан ажил, ажиллаж байсан нэгждээ аудит хамрах хугацааны дотор баталгаажуулалтын үйлчилгээ үзүүлэхгүй бөгөөд сүүлийн 12 сарын хугацаанд хариуцаж байсан үйл ажиллагаандаа баталгаажуулалтын үйлчилгээ үзүүлсэн бол бодитой хандлага алдагдсанд тооцно;
 - 4.7.2. Аудитор өмнө нь зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан үйл ажиллагаанд баталгаажуулалт хийх тохиолдолд Аудитын гүйцэтгэх удирдлага тухайн зөвлөх үйлчилгээний мөн чанар нь бодитой хандлагыг алдагдуулахгүй болохыг баталгаажуулж, аудиторын бодитой хандлагыг хамгаалах үүднээс нөөцийг хуваарилна;
 - 4.7.3. Аудитор нь өмнө хариуцан ажиллаж байсан үйл ажиллагаатай холбоотой зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд бодитой хандлага алдагдаж болзошгүй бол уг ажлыг хүлээж авахаас өмнө зөвлөх үйлчилгээг хүссэн талд энэ талаар мэдэгдэнэ;
 - 4.7.4. Аудитор зөвлөх үйлчилгээг үзүүлэхдээ удирдлагын үүрэг хариуцлагыг хүлээхгүй байх замаар бодитой хандлагыг хадгалж ажиллана;
 - 4.7.5. Аудитор хараат бус байдал алдагдаж болзошгүй аливаа нөхцөл байдлаас ангид байна.
- 4.8 Аудитор нь аудитын бус ажилд оролцох бол Аудитын гүйцэтгэх удирдлагын зүгээс аудиторын хараат бус байдал алдагдахгүй байх хамгаалалтыг хийж, шийдвэрийг (ТУЗ-ийн тогтоол, Аудитын хорооны шийдвэр, Гүйцэтгэх захирлын тушаал зэрэг) зохих ёсоор гаргуулна.
- 4.9 Аудитор нь гүйцэтгэж буй ажилтайгаа уялдуулан анхдагч эх сурвалжаас мэдээлэл олж авах, түүнийгээ үнэлэх, мэдээллээ ашиглах зэрэгт мэргэжлийн үүднээс хандаж, боломжит бүх хувилбараар нөхцөл байдалд тэнцвэртэй, бодитой үнэлэлт дүгнэлт өгнө.
- 4.10 Аудитор нь өөрийн ашиг сонирхол эсвэл бусдын үзэл бодлоос үүдэн бодитой хандлага алдагдах нөлөөнд өртөхөөс зайлсхийж, шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллана.

³ **Outsourcing** буюу дотоод аудитыг гуравдагч талаар гэрээний үндсэн дээр бүтэн гүйцэтгүүлэх хэлбэр

⁴ **Cosourcing** буюу дотоод аудиторуудтай холимог баг бүрдүүлэн гэрээний үндсэн дээр дотоод аудитыг хамтарч гүйцэтгэх хэлбэр

- 4.11 Аудиторууд хараат бус болон бодитой хандлага алдагдах, буурах нөхцөл үүссэн аливаа тохиолдлын талаар тэр даруй Аудитын гүйцэтгэх удирдлагад мэдэгдэж, уг мэдэгдлийг баримтжуулна. Аудитын гүйцэтгэх удирдлага асуудлыг хянан, шаардлагатай арга хэмжээг авна.
- 4.12 Аудитын гүйцэтгэх удирдлага нь ТУЗ эсвэл Аудитын хороонд хамгийн багадаа жилд нэг удаа ДАГ-ын хараат бус байдлын талаар мэдээлэл хийнэ. Аудитын гүйцэтгэх удирдлага нь дотоод аудитын хамрах хүрээг тодорхойлох, аудитын гүйцэтгэл, үр дүнг мэдээлэх зэрэгт ямар нэгэн хөндлөнгийн оролцоо, үр дагавар гарсан бол энэ талаар ТУЗ, Аудитын хороонд мэдэгдэнэ.

Хараат бус байдалд нөлөөлөх эрсдэлээс ангид байх

- 4.13 Аудитор нь дараах 5 төрлийн эрсдэлд өртсөн эсвэл өртөх нөхцөл бүрдвэл энэ талаар Аудитын гүйцэтгэх удирдлагад мэдэгдэнэ:

4.13.1 Ашиг сонирхлын зөрчлийн эрсдэл⁵

Танил талын харилцаа нь аудиторын хараат бус байдалд нөлөөлж улмаар аудитын ажилд нөлөөлж буй бүх байдлыг хэлнэ. Өөрийн гэр бүлийн, ойр дотнын, танил талын эсвэл санхүүгийн ашиг сонирхол нь өөрийн ажлыг буруугаар ашиглах, үйлдэлдээ бодит бус хандах нөхцөлийг бүрдүүлж буй бүх нөхцөлийг үүнд хамааруулан авч үзнэ:

- 4.13.1.а. Ажилтны өөрийн ашиг сонирхол;
- 4.13.1.б. Гэр бүлийн болон хувийн харилцаа холбоо;
- 4.13.1.в. Ажил олгогчийн ашиг сонирхол;
- 4.13.1.г. Санхүүгийн ашиг сонирхол;
- 4.13.1.д. Бизнесийн харилцааны ашиг сонирхол;
- 4.13.1.е. Давхар ажил эрхлэлт;
- 4.13.1.ё. Зээл болон баталгааны үйлчилгээтэй холбоотой ашиг сонирхол;
- 4.13.1.ж. Тусгай хөнгөлөлт, нөхцөлтэй холбоотой ашиг сонирхол;
- 4.13.1.з. Бэлэг авах, дайлуулах, авлигын эрсдэл.

4.13.2 Өөрөө өөрийнхөө ажлыг хянах эрсдэл⁶

Аудитор нь аудитын үйл ажиллагааны хүрээнд өөрийн өмнө нь гүйцэтгэж байсан ажилтай холбоотойгоор үүсч буй хараат бус байдалд нөлөө үзүүлэх нөхцөлийг хэлнэ. Өөрөө өөрийнхөө ажлыг хянах эрсдэлд зөвхөн өөртэй холбоотой биш, хамт ажилладаг аудиторын өмнөх ажилд аудит хийхэд үүсч болох эрсдэлийг хамааруулан авч үзнэ:

- 4.13.2.а. Өөрийн хийж гүйцэтгэсэн ажил;
- 4.13.2.б. Өмнө нь ажиллаж байсан нэгж, нэгжийн удирдлага, ажилтнууд;
- 4.13.2.в. Хамт ажиллаж байгаа дотоод аудиторын хийж гүйцэтгэсэн ажил.

4.13.3 Танил талын эрсдэл⁷

Аудитор нь аудитлагдаж буй нэгж эсвэл нэг үйл ажиллагааг олон удаагийн давтамжтайгаар дараалан аудитлахад үүсч буй хараат бус байдалд нөлөөлөх нөхцөлийг

⁵ *Self-interest threat*

⁶ *Self-review threat*

⁷ *Familiarity threat*

хэлнэ. Аудиторуудыг энэ эрсдэлээс ангид байлгах дараах урьдчилан сэргийлэх ажлыг хийнэ:

4.13.3.а. Тухайн нэг нэгж эсвэл үйл ажиллагаанд нэг аудиторыг дараалан 3-аас дээш удаа ажиллуулахгүй, үүнд мэдээллийн технологийн аудиторууд хамаарахгүй;

4.13.3.б. Аудитын багийн ахлагч, аудитын багийн гишүүдийг солих, үүнд мэдээллийн технологийн аудиторууд хамаарахгүй;

4.13.3.в. Аудитын дүгнэлтийг хараат бусаар (аудитын багт ороогүй дотоод аудитын албан тушаалтнаар эсвэл гэрээний дагуух зөвлөхөөр) хянуулах.

4.13.4 **Өмгөөллийн эрсдэл⁸**

Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг өмгөөлснөөс үүсч буй хараат бус байдалд нөлөөлөх нөхцөлийг хэлнэ. Өмгөөллийн эрсдэл үүсгэхгүй байх дараах хамгаалалтуудыг хийнэ:

4.13.4.а. Дотоод аудит нь Гүйцэтгэх удирдлагын гаргасан аливаа шийдвэр, үйлдэл, ажлын үр дүнгийн өмнөөс хариуцлага хүлээхгүй, мөн Гүйцэтгэх удирдлагаас явуулж буй үйл ажиллагааг аливаа хэлбэрээр өмгөөлөхгүй;

4.13.4.б. Аудитор нь банкны ирээдүйн үйл ажиллагаанд баталгаа гаргасан мэдэгдэл, мэдээлэл хийхгүй;

4.13.4.в. Аудитор нь Банкны нэрийн өмнөөс хэрэг мөрдөлт, шүүхийн үйл ажиллагаанд тал болж оролцох, өмгөөлөх, аливаа хэлбэрээр Банкныг төлөөлөх үүрэг гүйцэтгэхгүй. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу явагдах шүүх, мөрдөн шалгах байгууллагын ажиллагаанд гэрчээр оролцох, баримт бичиг, мэдээлэл, техник хэрэгсэлдээ үзлэг, шалгалт хийлгүүлэх зэрэг албадлагын шинжтэй оролцоо нь энэхүү заалтад хамаарахгүй бөгөөд эдгээр тохиолдолд аудитор нь банкны холбогдох бодлого, журам, зааврыг баримтлан, банкны хуульчидтай хамтран ажиллаж, тэднийг шаардлагатай мэдээллээр хангана.

4.13.5. **Сүрдүүлгийн эрсдэл⁹**

Аудиторыг ажлаа хэвийн сэтгэл зүйтэйгээр ажиллах боломжгүй болгож буй ажил үүрэг, удирдлагын даалгавраас шалтгаалж үүсч буй нөхцөлийг ойлгоно:

4.13.5.а. Аудиторын дасан зохицох, мэргэжлийн дадлыг сайн эзэмшээгүй үед нь тохироогүй эсвэл хэт өндөр шаардлага бүхий ажилд хуваарилах, банкны болон гаднын байгууллагын өндөр албан тушаалтантай шууд харьцах аудитын ажлыг гүйцэтгүүлэх;

4.13.5.б. Аудиторын шийдвэр, үнэлгээ, дүгнэлтээс эсрэг буюу зарчмын хувьд ялгаатай үнэлгээ, дүгнэлт хийхийг шаардах, нөлөө үзүүлэхийг оролдох;

4.13.5.в. Аливаа давуу байдлыг (албан тушаал, насны зөрүү, илүү олон жилийн туршлага зэрэг) ашиглаж аудиторын сэтгэл зүйд нөлөөлөх аливаа үйлдэл, эс үйлдэл, дарамт шахалт;

4.13.5.г. Дээрх нөхцөлүүд нь аудиторын гэр бүлийн гишүүдэд бий болсон бол мөн сүрдүүлгийн эрсдэлд өртсөн гэж үзнэ.

⁸ *Advocacy threat*

⁹ *Intimidation threat*

Олон улсын мэргэжлийн практикийн хүрээг дагаж мөрдөх

4.14 ДАГ нь ОУМПХ (IPPF)-ийн заавал хэрэгжүүлэх бүрэлдэхүүн болох ДАДС, Сэдэвчилсэн шаардлагыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана. ОУМПХ (IPPF)-ний нэмэлтээр хэрэгжүүлэх бүрэлдэхүүн болох Дэлхийн удирдамжийг аудитын аргачлалд удирдлага болгон ашиглаж болно.

ОУМПХ-ний заавал хэрэгжүүлэх бүрэлдэхүүн:

4.14.1. Дотоод аудитын дэлхийн стандарт:

Бүлэг I: Дотоод аудитын зорилго

- Бүлэг II: Ёс зүй ба мэргэжлийн байдал
 - Зарчим 1. Шударга байдлыг харуулах
 - Стандарт 1.1. Шударга байдал ба мэргэжлийн эр зориг
 - Стандарт 1.2. Байгууллагын ёс зүйн хүлээлт
 - Стандарт 1.3. Хууль тогтоомж болон ёс зүйн зан байдал
 - Зарчим 2. Бодитой хандах
 - Стандарт 2.1. Хувь хүний бодитой хандлага
 - Стандарт 2.2. Бодитой хандлагыг хамгаалах
 - Стандарт 2.3. Бодитой хандлага алдагдсан тохиолдлуудыг мэдэгдэх
 - Зарчим 3. Чадамжтай байх
 - Стандарт 3.1. Чадамж
 - Стандарт 3.2. Мэргэжлийн тасралтгүй хөгжил
 - Зарчим 4. Мэргэжлийн ур дүйтэй ажиллах
 - Стандарт 4.1. Дотоод аудитын дэлхийн стандартад нийцэх
 - Стандарт 4.2. Мэргэжлийн ур дүй
 - Стандарт 4.3. Мэргэжлийн үл итгэх хандлага
 - Зарчим 5. Нууц хадгалах
 - Стандарт 5.1. Мэдээллийг ашиглах
 - Стандарт 5.2. Мэдээллийг хамгаалах
- Бүлэг III. Дотоод аудитын үйл ажиллагааг засаглах
 - Зарчим 6. ТУЗ-өөс эрх олгох
 - Стандарт 6.1. Дотоод аудитын бүрэн эрх (эрх, үүрэг, хариуцлага)
 - Стандарт 6.2. Дотоод аудитын дүрэм
 - Стандарт 6.3. ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын дэмжлэг
 - Зарчим 7. Хараат бусаар байрших
 - Стандарт 7.1. Зохион байгуулалтын хараат бус байдал
 - Стандарт 7.2. Аудитын гүйцэтгэх удирдлагын мэргэшил
 - Зарчим 8. ТУЗ-ийн хяналтад байх
 - Стандарт 8.1. ТУЗ-тэй харилцах
 - Стандарт 8.2. Нөөц
 - Стандарт 8.3. Чанар
 - Стандарт 8.4. Хөндлөнгийн чанарын үнэлгээ
- Бүлэг IV. Дотоод аудитын үйл ажиллагааг удирдах
 - Зарчим 9. Стратегитай төлөвлөх
 - Стандарт 9.1. Засаглал, эрсдэлийн удирдлага, хяналтын үйл явцыг ойлгох
 - Стандарт 9.2. Дотоод аудитын стратеги

- Стандарт 9.3. Аргагүй
- Стандарт 9.4. Дотоод аудитын төлөвлөгөө
- Стандарт 9.5 Зохицуулах ба бусдын ажилд түшиглэх
- Зарчим 10. Нөөцийг удирдах
 - Стандарт 10.1. Санхүүгийн нөөцийг удирдах
 - Стандарт 10.2. Хүний нөөцийг удирдах
 - Стандарт 10.3. Технологийн нөөц
- Зарчим 11. Үр дүнтэй харилцааг хэрэгжүүлэх
 - Стандарт 11.1. Оролцогч талуудтай харилцаа тогтоох ба харилцах
 - Стандарт 11.2. Үр дүнтэй харилцах
 - Стандарт 11.3. Үр дүнг хүргэх
 - Стандарт 11.4. Алдаа ба орхигдуулсан зүйлс
 - Стандарт 11.5. Эрсдэлийг хүлээн авсан талаар мэдээлэх
- Зарчим 12. Чанарыг сайжруулах
 - Стандарт 12.1. Дотоод чанарын үнэлгээ
 - Стандарт 12.2. Гүйцэтгэлийг хэмжих
 - Стандарт 12.3. Аудитын ажлын гүйцэтгэлийг хянах ба сайжруулах
- Бүлэг V. Дотоод аудитын үйлчилгээ үзүүлэх
 - Зарчим 13. Аудитын ажлыг үр дүнтэй төлөвлөх
 - Стандарт 13.1. Аудитын ажлын туршид харилцах
 - Стандарт 13.2. Аудитын ажлын эрсдэлийн үнэлгээ
 - Стандарт 13.3. Аудитын ажлын зорилтууд болон хамрах хүрээ
 - Стандарт 13.4 Үнэлгээний шалгуур
 - Стандарт 13.5. Аудитын ажлын нөөц
 - Стандарт 13.6. Аудитын ажлын хөтөлбөр
 - Зарчим 14. Аудитын ажлыг гүйцэтгэх
 - Стандарт 14.1. Дүн шинжилгээ ба үнэлгээнд мэдээлэл цуглуулах
 - Стандарт 14.2. Дүн шинжилгээ ба боломжит аудитын илрүүлэлт
 - Стандарт 14.3. Аудитын илрүүлэлтийг үнэлэх
 - Стандарт 14.4. Зөвлөмж ба арга хэмжээний төлөвлөгөө
 - Стандарт 14.5. Аудитын ажлын дүгнэлт
 - Стандарт 14.6. Аудитын ажлын баримтжуулалт
 - Зарчим 15. Аудитын ажлын үр дүнг хүргэх болон арга хэмжээний төлөвлөгөөг хянах
 - Стандарт 15.1. Аудитын ажлын эцсийн тайлан
 - Стандарт 15.2. Зөвлөмж эсхүл арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг баталгаажуулах

4.14.2. Сэдэвчилсэн шаардлага

- Кибер аюулгүй байдлын сэдэвчилсэн шаардлага
- Гуравдагч талын сэдэвчилсэн шаардлага
- Байгууллагын зан төлөвийн сэдэвчилсэн шаардлага гэх мэт.

ТАВ. ДОТООД АУДИТЫН ЭРХ

- 5.1. ДАГ нь өөрийн ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай хангалттай хэмжээний эрхтэй байх бөгөөд энэхүү эрхийн хэмжээ нь үүргээ бүрэн биелүүлэхэд нь хангалттай байгаа эсэхийг ТУЗ, Аудитын хороо хянана.
- 5.2. Аудиторууд нь Банкны үйл ажиллагаа, үйл явц, гүйлгээ, баримт, биет болон биет бус хөрөнгө, хүний нөөцийн мэдээлэл, аудитад хамрагдаж буй үйл ажиллагааг хариуцсан ажилтнууд, нууц, нууцлалтай мэдээлэл, баримт, бүртгэл, програм хангамж, сервер, компьютер зэрэгт хандах, нэвтрэх, мэдээлэл авах эрхтэй бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй болно.
- 5.3. ДАГ нь аудитын ажлыг гүйцэтгэж, дуусгахад шаардлагатай хүний нөөц болон бусад нөөцөөр (аюулгүй орчин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, мэдээлэл зэрэг) хангагдаж, шаардлагатай тусалцаа, үйлчилгээ авах эрхтэй байна.
- 5.4. Аудитын гүйцэтгэх удирдлага нь дотоод аудитын үйл ажиллагааны гол асуудлаар (эрсдэл өндөртэй үйл ажиллагааны баталгаажуулалт, зөвлөх үйлчилгээ, хүний нөөц, аудиторын хараат бус байдал зэрэг) Аудитын хорооны даргаас саналыг нь сонсож, чиглэл авч ажиллана.
- 5.5. ДАГ-ын ажилтнууд Гүйцэтгэх удирдлагын харъяанд байгаа удирдах болон гүйцэтгэх түвшний ажилтнуудтай чөлөөтэй харьцах, уулзах, асуулга болон мэдээлэл авах эрхтэй.
- 5.6. Аудитын гүйцэтгэх удирдлага нь ТУЗ, Аудитын хороо, Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдтэй ямар нэгэн хязгаарлалтгүйгээр шууд уулзах, харилцах, санал солилцох эрхтэй байна.
- 5.7. Аудитын гүйцэтгэх удирдлага нь санхүүгийн тайлагнал, зөвлөх үйлчилгээний үр дүн, байгууллагын Засаглал, Эрсдэлийн удирдлага, Хяналтын чиг үүрэгтэй холбоотой асуудлаар мэдээлэл авах зорилгоор ТУЗ, Хувьцаа эзэмшигчдийн хуралд Хурал даргалагчийн зөвшөөрлөөр оролцож болно.

ЗУРГАА. ДОТООД АУДИТЫН ҮҮРЭГ

- 6.1. Дотоод аудитын үйл ажиллагаанд оролцож буй бүх ажилтнууд болох Аудитын гүйцэтгэх удирдлага, Аудит хариуцсан захирал, Чанарын хяналтын ахлах ажилтан, Чанарын хяналтын ажилтан, Ахлах аудитор, Аудитор нь ялгаатай түвшний үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
- 6.2. Аудитын гүйцэтгэх удирдлага болон ДАГ-ын ажилтнууд дараах үүрэг, хариуцлагыг хүлээж ажиллана:
 - 6.2.1 Хамгийн багадаа жилд нэг удаа ТУЗ болон Аудитын хороонд Дотоод аудитын төлөвлөгөөг хянуулж, батлуулах;
 - 6.2.2 ТУЗ болон Аудитын хороотой дотоод аудитын нөөцийн талаар хэлэлцэж, шаардлагатай нэмэлт нөөцийг шийдвэрлүүлэх болон нөөцийн хязгаарлалтын асуудлыг шийдвэрлүүлэх;
 - 6.2.3 Банкны бизнес, эрсдэл, үйл ажиллагаа, төсөл-хөтөлбөр, бүтэц, систем, хяналт зэрэгт орсон өөрчлөлттэй холбоотойгоор Дотоод аудитын төлөвлөгөөг дахин хянаж, шаардлагатай өөрчлөлтийг хийх;

- 6.2.4 Дотоод аудитын төлөвлөгөөнд оруулах шаардлагатай түр зуурын өөрчлөлт бүрийг Аудитын хороонд танилцуулан, шийдвэрлүүлэх;
 - 6.2.5 Төлөвлөгдсөн аудит хамрах хүрээ, зорилгынхоо хүрээнд гүйцэтгэгдсэн эсэх, аудитын нөөц болон аудитын үйл ажиллагааны (шалгах хуудас, ажиглалт, ярилцлага, магадлал, лавлагаа гэх мэт аудитын бүх төрлийн үйл ажиллагаа) баримтжуулалт бүрэн эсэхэд хяналт тавих, дотоод аудитын тайлангийн дүгнэлт, зөвлөмжтэй холбоотойгоор холбогдох нэгжтэй харилцаа холбоотой ажиллах;
 - 6.2.6 Аудитын илрүүлэлтэд чиглэсэн арга хэмжээ буюу өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд эргэн хяналтын аудитыг гүйцэтгэх, улирал тутам зөвлөмжийн хэрэгжилтийг нэгтгэн дүгнэх, үр дүнг ТУЗ, Аудитын хороонд танилцуулж, Гүйцэтгэх удирдлагад мэдээлэх;
 - 6.2.7 Үнэнч шударга, бодитой, нууц хадгалах, ур чадвартай байх зарчмуудыг хэрэгжүүлж ажиллах, дотоод аудиторуд эдгээр зарчмуудыг хэрэгжүүлж ажиллахад дэмжлэг үзүүлж ажиллах;
 - 6.2.8 Дотоод аудитын үйл ажиллагааг Дотоод аудитын бодлоготой нийцүүлж явуулахад шаардлагатай мэдлэг, туршлага, арга барилыг олж авах, эзэмшүүлэх, тасралтгүй сурган хөгжүүлэх;
 - 6.2.9 Банкинд нөлөө үзүүлж болзошгүй нөхцөл байдал, шинээр үүсч буй асуудал, эрсдэл зэрэг нь үйл ажиллагаанд хэрхэн нөлөө үзүүлэх талаар анхаарал хандуулж, Гүйцэтгэх удирдлагатай шаардлагатай харилцаа холбоо (уулзах, хэлэлцэх, лавлах, мэдээлэл хүлээн авах зэрэг) тогтоож ажиллах;
 - 6.2.10 Дотоод аудитын хөгжлийн чиг хандлагыг нэвтрүүлж, үйл ажиллагаагаа оновчлон ажиллах;
 - 6.2.11 ДАГ-т болон аудитын үйл ажиллагаанд Дотоод аудитын бодлого, журмыг чанд мөрдөх; аудитын гарын авлага болон аргачлалыг шинэчлэн ажиллах;
 - 6.2.12 Дотоод аудитын бодлоготой зөрчилдөөгүй бол банкны бүхий л бодлого, журам, зааврыг мөрдөж ажиллах. Банкны бодлого, журам, зааврыг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа маргаантай асуудал үүсвэл үүнийг Гүйцэтгэх удирдлагатай зөвшилцөж шийдвэрлэх;
 - 6.2.13 Дотоод аудитын стандартыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Монгол улсын хууль тогтоомж, эрх зүйн акттай зөрчилдөх тохиолдол үүсвэл, зөрчигдөж байгаа хэсгүүд дээр тодруулга бичиж, стандартын бусад хэсгийг хэрэгжүүлж ажиллана.
- 6.3 “Дотоод аудитын газрын журам”-д дотоод аудитын албан тушаалтнуудын хүлээх үүргийг нарийвчлан тусгасан байна.

ДОЛОО. ДОТООД АУДИТЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Дотоод аудит болон ТУЗ, Аудитын хороо

- 7.1. Банкны дотоод аудитын хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангахтай холбоотой дараах ажлууд ТУЗ болон Аудитын хороонд хамаарна:
 - 7.1.1. Дотоод аудитын бодлогыг хэлэлцэж батлах;
 - 7.1.2. Дотоод аудитын төлөвлөгөөг хэлэлцэж батлах;

- 7.1.3. ДАГ-ын төсөв болон нөөцийг хэлэлцэж батлах;
- 7.1.4. Дотоод аудитын газрын үйл ажиллагаатай холбоотой журмуудыг хэлэлцэж батлах;
- 7.1.5. Аудитын гүйцэтгэх удирдлага, Аудит хариуцсан захирлын томилгоо болон албан тушаалаас нь чөлөөлөх тухай асуудлыг хариуцах;
- 7.1.6. Аудитын гүйцэтгэх удирдлага, ДАГ-ын ажилтнуудын цалин хөлс, урамшуулал, нийгмийн хангамжийн асуудлыг авч хэлэлцэх.

Дотоод аудит болон Гүйцэтгэх удирдлага

- 7.2. Дотоод аудит нь үндсэн үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай Банкны мэдээллийг тухай бүр хүлээн авах үүднээс Банкны Гүйцэтгэх удирдлагын холбогдох хороодод саналын эрхгүй орох, бусад сувгаар Банкны стратеги, бизнесийн төсөв төлөвлөгөө, гүйцэтгэл, үйл ажиллагааны өөрчлөлтийн талаарх мэдээллээр чөлөөтэй хангагдана.
- 7.3. ДАГ нь банкны Гүйцэтгэх удирдлага, түүний харъяа хороод, нэгжийг шаардлагатай тохиолдолд дотоод аудиттай холбоотой мэдээллээр хангах, Банкны нэрийн өмнөөс зохицуулагч байгууллагад шаардлагын дагуу дотоод аудитын үр дүнг албан ёсоор хүргүүлнэ.
- 7.4. Гүйцэтгэх удирдлагын зүгээс ДАГ-ын үйл ажиллагаанд хүндэтгэлтэйгээр хандаж, аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэх, дотоод аудитад ач холбогдол өгч ажиллана.
- 7.5. Дотоод аудиторуудыг үүргээ гүйцэтгэхэд нь нөхцөл бололцоогоор хангах, үр дүнтэй хамтран ажиллахыг ажилтнууддаа уриалж, хамтын ажиллагааг үр дүнтэй байлгахад санаачилгатай байна.
- 7.6. Банкны эрсдэлийн үнэлгээ, дотоод хяналт, комплайнстай холбоотой ажлыг давхардуулахгүй, орхигдуулахгүй, илүү зардал гаргахгүй байх үүднээс дотоод аудитын ажлын үр ашигтай байдалд дэмжлэг үзүүлэхийг Гүйцэтгэх удирдлагаас хүсч болно.

Дотоод аудит болон Хөндлөнгийн аудит

- 7.7. Аудитын гүйцэтгэх удирдлага нь дотоод аудитын ажлыг хөндлөнгийн аудитын үйл ажиллагаатай уялдуулан оновчтой зохион байгуулах, хамтран ажиллах ажлыг хариуцна.
- 7.8. Дотоод аудит нь хөндлөнгийн аудитыг дэмжин, хөндлөнгийн аудитаар олж илрүүлсэн зүйлс, дүгнэлттэй нь танилцаж, аудитын тайлангаарх (баталгаажуулах болон зөвлөх үйлчилгээний) мэдээллээ солилцож ажиллана.
- 7.9. Аудитын ажлыг давхардуулахгүй, орхигдуулахгүй, илүү зардал гаргахгүй байх үүднээс дотоод аудитын ажлын үр ашигтай байдалд дэмжлэг үзүүлэхийг ТУЗ, Аудитын хорооноос хүсч болно.
- 7.10. Дотоод аудит нь шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн аудиторуудтай мэдээлэл солилцох уулзалтыг зохион байгуулж болно.

НАЙМ. ДОТООД АУДИТЫН ТАЙЛАГНАЛТ

- 8.1. Дотоод аудит нь чиг үүргийн болон захиргааны асуудлаар ТУЗ болон Аудитын хорооны харьяанд ажиллана.

- 8.2. Дотоод аудитын үйл ажиллагаагаар боловсруулагдаж, бий болсон аудитын тайлан, аудитын бусад баримт бичгүүд нь ДАГ-ын ажилтнуудаар бэлтгэгдэж, Аудит хариуцсан захирал болон Аудитын гүйцэтгэх удирдлагаар хянагдаж, Аудитын гүйцэтгэх удирдлагаар батлагдсан байна.
- 8.3. Банкны Дотоод аудитын үйл ажиллагааны үр дүнд гарах аливаа дүгнэлт, үнэлгээ нь зөвхөн ДАГ-ын нэрээр гарах бөгөөд дотоод аудитын тайланг ТУЗ, Аудитын хороонд тайлагнаж, Гүйцэтгэх удирдлагад мэдээлнэ.
- 8.4. Дотоод аудитын тайланд аудитаар илэрсэн зүйлстэй холбоотойгоор Гүйцэтгэх удирдлагын зүгээс авбал зохих хариу арга хэмжээ болон засаж, залруулах шаардлагатай үйлдлүүдийн талаар тусгасан байна. Аудитаар илэрсэн зүйлс нь аудитын явцад залруулагдсан эсэх, Гүйцэтгэх удирдлагын зүгээс засаж, залруулах арга хэмжээг ямар хугацаанд авах талаар тодорхой тусгана.
- 8.5. Аудитын үйл ажиллагаагаар илрүүлсэн зүйлс, дүгнэлт болон зөвлөмжийн чанарт Аудитын гүйцэтгэх удирдлага, ДАГ хариуцлага хүлээнэ.
- 8.6. Ноцтой зөрчлийн илэрсэн байдал, түүний хяналтын асуудлууд, залилангийн эрсдэлүүд, засаглалын асуудлууд болон ТУЗ, Аудитын хороо, Гүйцэтгэх удирдлагын мэдвэл зохих бусад асуудлуудыг аудитын тайланд заавал тусгана.
- 8.7. Аудитын гүйцэтгэх удирдлага нь аудитын төлөвлөгөөний гүйцэтгэл, аудитаар илэрсэн анхаарвал зохих асуудлууд, зөвлөмжийн хэрэгжилтийг улирал бүр; дотоод аудитын зорилго, эрх, үүрэг хариуцлага, зохион байгуулалтын хараат бус байдал, нөөцийн хуваарилалт, аудитын төлөвлөгөөний дэлгэрэнгүй гүйцэтгэлийг жил бүр ТУЗ, Аудитын хороонд тайлагнана.

ЕС. ДОТООД АУДИТЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

- 9.1. ДАГ нь дотоод аудитын ажлыг гүйцэтгэх хангалттай мэдлэг, ур чадвар, туршлага болон мэргэшсэн ажилтнуудаар хангагдсан байна.
- 9.2. Дотоод аудитын газрын аудиторууд нь үнэнч шудрага, найдвартай, гярхай, санаачилгатай, сахилга баттай, харилцааны болон багаар ажиллах чадвар өндөртэй байна.
- 9.3. Дотоод аудиторууд ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай шинэ мэдлэг, ур чадвар эзэмших болон мэргэшлээ дээшлүүлэх зорилгоор сургалтад тогтмол хамрагдаж байна.
- 9.4. ДАГ-ын ажилтнуудын сургалт хөгжлийн бодлогыг дотоод аудитын хөгжлийн хандлага, аудитын ажлын төлөвлөгөө, сайжруулалтын хөтөлбөрт үндэслэн системтэйгээр хэрэгжүүлнэ.
- 9.5. Дотоод аудитын газрын аудиторуудыг Аудитын гүйцэтгэх удирдлагын санал болгосноор “Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх ажлын албаны журам”-д заасны дагуу ТУЗ-өөс баталсан орон тоонд багтаан, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын шийдвэрээр томилж, чөлөөлнө.
- 9.6. Аудитын гүйцэтгэх удирдлага нь дотоод аудиторуудын бодит орлогын талаар жил бүр хэлэлцэж, цалин хөлс, урамшууллын асуудлаар ТУЗ, Аудитын хороонд мэдээлэл өгч, холбогдох шийдвэрийг гаргуулж ажиллана.
- 9.7. ДАГ-ын ажилтнуудын цалин хөлс, шагнал, урамшуулал, нийгмийн хангамж нь Гүйцэтгэх удирдлагын харьяа банкны ажилтнуудаас багагүй байна.
- 9.8. Энэ бодлогод тусгайлан заагаагүй аливаа асуудлыг “Худалдаа, хөгжлийн банкны Хөдөлмөрийн дотоод журам”-аар зохицуулна.

АРАВ. ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ЧАНАР

- 10.1. Аудитын ажлын чанарыг Аудитын гүйцэтгэх удирдлага, Аудит хариуцсан захирал, ДАГ-ын ажилтнууд бүгд хариуцна.
- 10.2. Аудитын ажлын чанарыг Аудитын гүйцэтгэх удирдлага дараах арга замаар хангаж ажиллана:
 - 10.2.1. Аудитын ажлыг төлөвлөх гүйцэтгэх, аудитын үр дүнг хүргэх болон зөвлөмжийн хэрэгжилтийг эргэн хянах үе шат бүрт аудитын ажлыг зохистой хянан удирдах байдлаар;
 - 10.2.2. Аудитын ажлыг Дотоод аудитын газрын журам болон холбогдох аргазүй, аргачлал, ДАДС-ын дагуу гүйцэтгэж, хянаж удирдан, баримтжуулсан байдал нь шаардлагад нийцсэн эсэхийг шалгах чанарын хяналтаар.
- 10.3. ДАГ нь нийт үйл ажиллагааныхаа чанарыг чанарын баталгаажуулалт, сайжруулалтын хөтөлбөрөөр зохистой түвшинд байлгах ба уг хөтөлбөр нь дотоод аудитын бүх үе шатыг бүрэн хамарсан, тасралтгүй үргэлжлэх, дүгнэлт болон эргэн хяналттай байх шинж чанартай байна.
- 10.4. Хөтөлбөр нь Банкны дотоод аудитын үйл ажиллагаа ДАДС, сэдэвчилсэн шаардлагатай нийцэж буй эсэхийг, Банкны дотоод аудитын үйл ажиллагааны үр ашиг болон үр дүнтэй байдлыг үнэлж, нийцлийг хангах, сайжруулах боломжуудыг тодорхойлсон байна.
- 10.5. Чанарын баталгаажуулалт, сайжруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг Чанарын удирдлагын алба, Аудитын гүйцэтгэх удирдлага хариуцах ба хөтөлбөрийн үр дүнг тухай бүр ДАГ-ын ажилтнуудад мэдээлж, ТУЗ болон Аудитын хороонд танилцуулна.
- 10.6. Банкны дотоод аудитын үйл ажиллагаанд ДАДС-д заасны дагуу 5 жилд хамгийн багадаа нэг удаа чанарын хөндлөнгийн үнэлгээ хийлгэнэ. Үүнийг Аудитын гүйцэтгэх удирдлага болон ЧУА хариуцна.
- 10.7. Чанарын хөндлөнгийн үнэлгээний үр дүнг ДАГ-ын ажилтнуудад мэдээлж, ТУЗ, Аудитын хороо, Гүйцэтгэх удирдлагад танилцуулж ажиллана.